


2025 ОНЫ УУР АМЬСГАЛЫН ЖИЛИЙН ТОЙМ

1. Агаарын температур

Монгол орноор дунджилсан 2025 оны жилийн агаарын дундаж температур 1.6°C ба уур амьсгалын өөрчлөлт харьцангуй сул илэрч байсан 1961-1990 оны дунджаас 2.23°C -аар дулаан буюу 1940 оноос хойш ажиглагдсан 6 дахь дулаан жил болж өнгөрлөө.

Жилийн агаарын дундаж температурын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 1) говийн бүс нутгийн өмнөд, Алтайн өвөр говиор $+6.1...+10.3^{\circ}\text{C}$, тал хээрийн бүс нутгаар болон Их нууруудын хотгор орчмоор $+3.1...+6.0^{\circ}\text{C}$, Алтай, Хангайн нуруу, Хөвсгөлийн өндөр уулс Дархадын хотгор орчмын нутгаар $-3.1...-5.9^{\circ}\text{C}$, бусад нутгаар $-3.0...+3.0^{\circ}\text{C}$ орчим байсан байна.




Зураг 1. 2025 оны жилийн агаарын дундаж температурын орон зайн тархалт

2025 оны агаарын дундаж температурыг улирлаар авч үзвэл өвлийн улиралд нийт нутгийн 13.9% нь ОЖД-аас -1.1°C -ээс -6.8°C (ялангуяа Ховдын Цэцэг, Мөст, Зэрэг, Баян-Өлгийн Дэлүүн, Увсын Завхан орчмоор -3.9°C -ээс -6.8°C -аар) хүйтэн, 26.5% нь дунджийн орчим, 59.6% дунджаас $+1.1$ -аас $+3.8^{\circ}\text{C}$ -аар дулаан байсан байна (Зураг 2).

Хаврын улиралд нутгийн дийлэнх хэсэг буюу 76.5%-д нь агаарын дундаж температур ОЖД-аас $+1.1^{\circ}\text{C}$ -аас $+2.7^{\circ}\text{C}$ -аар дулаан, 23.5% нь дунджийн орчим байжээ.


Зуны улиралд нийт нутгийн тал хувь буюу 50.7%-д агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, үлдсэн 49.3%-д дунджийн орчим байжээ. Тухайлбал, баруун, говийн болон төвийн бүсийн зарим нутгаар агаарын дундаж температур ОЖД-аас $+1.1^{\circ}\text{C}$ -аас $+2.2^{\circ}\text{C}$ -аар дулаан байсан байна.

Намрын улиралд агаарын дундаж температур нийт нутгийн дийлэнх хэсгээр (82.4%) дунджийн орчим, 3.7%-д дунджаас дулаан, 14%-д буюу Завхан, Баянхонгор, Өвөрхангай зарим бүс нутгаар дунджаас -1.2°C -аас -2.6°C -аар хүйтэн байжээ. (Зураг 2).



Зураг 2. 2025 оны улирлын агаарын дундаж температурын ОЖД-аас (норм 1991-2020 он) хазайх хазайлт


Сүүлийн 5 жилийн сар бүрийн агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын утгыг харьцуулж үзэхэд (зураг 3) 2025 оны 1, 3-4, 6-7, 11-12 дугаар саруудад дунджаас $+1.0$ - ээс $+3.6^{\circ}\text{C}$ -аар дулаан, 10 дугаар сард дунджаас -2.9°C -аар хүйтэн байжээ. Харин 2, 5, 8-9 дүгээр саруудад агаарын дундаж температур ОЖД-ын орчим байсан байна.



Зураг 3. 2021-2025 оны сарын бүрийн агаарын дундаж температурын ОЖД-аас (норм 1981-2010 он) хазайх хазайлтын харьцуулалт

2. Хур тунадас

Монгол орноор дунджилсан 2025 оны жилийн нийлбэр хур тунадас 223.5 мм буюу олон жилийн дунджийн орчим хур тунадас орсон жил болж өнгөрлөө. Жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалтыг авч үзэхэд (зураг 4) Хэнтэйн нуруу, Хэрлэн, Онон, Улз, Орхон зэрэг томоохон голын ай сав орчмоор 411.2-455.6 мм, Хөвсгөлийн уулс, Хангайн нуруу, тал хээрийн бүс нутгийн зарим хэсгээр 301.6-396.7 мм, Алтайн нуруу, бусад нутгаар 101.5-296.8 мм, Их нууруудын хотгор болон говийн бүс нутгийн зарим хэсгээр 50-100 мм, Алтайн өвөр говь болон Их нууруудын хотгорын баруун хойд хэсэг (Баян-Өлгийн Баяннуур, Увсын Ховд)-ын орчмоор хамгийн бага буюу 21.5-49.6 мм орсон байна. Жилийн нийлбэр тунадасны хамгийн их утга нь Хэнтийн аймгийн Дадал суманд 455.6 мм тунадас оржээ.




Зураг 4. 2025 оны жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалт

2025 оны өвлийн улиралд нийт нутгийн 36.0%-д ахиу (баруун болон говийн бүсийн зарим хэсгээр 2-3 дахин их тунадас орсон), 4.4%-д дунджийн орчим, 59.6%-д ОЖД-аас бага хур тунадас орсон.

Хаврын улиралд нийт нутгийн 38.2% -д ОЖД-аас бага, 50.7% -д ахиу, 11.0%-д дунджийн орчим хур тунадас орсон. Зүүн болон говийн бүсийн нутгаар дунджаас харьцангуй ахиу хур тунадастай байлаа.


Зуны улиралд нийт нутгийн ихэнх хэсэг буюу 61%-д дунджаас бага, 19.9%-д дунджийн орчим, 19.1%-д ахиу хур тунадас орсон. Ялангуяа зүүн бүс нутгаар ОЖД-аас ахиу хур тунадастай байсан.

Намрын улиралд нийт нутгийн дийлэнх буюу 75.7% -д дунджаас ахиу (ялангуяа төв болон говийн бүсийн зарим хэсгээр дунджаас 60%-иас их), 14.0%-д дунджийн орчим, 10.3% -д бага хур тунадас орсон байна. (Зураг 5).



Зураг 5. 2025 оны улирлын нийлбэр хур тунадасны ОЖД-аас (норм 1991-2020 он) хазайх хазайлт

Сүүлийн 5 жилийн сар бүрийн нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын утгыг харьцуулж үзэхэд (зураг 6) 2025 оны 11 дүгээр сард дунджаас 60%-иас их, 1, 3, 5, 9 дүгээр саруудад 20-40%-иар тус тус ахиу, 7-8,10 сард дунджийн орчим, харин 2, 4, 12 дугаар саруудад дунджаас 20-60%-иар, 6 дугаар 20%-иас бага тус тус бага хур тунадас орсон байна.




Зураг 6. 2021-2025 оны сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас (норм 1981-2010 он) хазайх хазайлтын харьцуулалт

3. Экстремаль утгууд

2025 онд температурын үнэмлэхүй их утга Баянхонгор аймгийн Шинэжинст сум Эхийнголд агаарт 41.8°C, Улаанбаатар хотод хөрсөн дээр 73°C хүрч халсан бол үнэмлэхүй


бага утга Завханы Отгон суманд агаарт -45.6°C , хөрсөн дээр -50°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Дорнод аймгийн Дашбалбар суманд 7 дугаар сарын 23-нд 69.8 мм тунадас орсон. Агаарын даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 968.9 гПа, харин үнэмлэхүй бага утга Баянхонгорын Баянбулагт 762.1 гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурдны үнэмлэхүй их утга Говь-Алтайн аймгийн Бугат суманд 38 м/с хүрсэн байна (Зураг 7).



Зураг 7. Тус жилд ажиглагдсан үнэмлэхүй утгууд

4. Цасан бүрхүүлийн зузаан

2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт нутгийн 74%-д цасан бүрхүүл тогтсон бөгөөд цасны зузаан хамгийн ихдээ Увс аймгийн Ховд, Завхан аймгийн Цэцэн-Уул, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумдын нутгаар 30–40 см хүрсэн.



Зураг 8. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар цасны зузаан (см)

5. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл

2025 онд улсын хэмжээнд 10 төрлийн, нийт 73 удаагийн цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдэл тохиолдсоноос аюултай үзэгдэл 61 удаа, гамшигт үзэгдэл 12 удаа бүртгэгдсэн. Гамшигт үзэгдлийн улмаас 2 хүн амь насаа алдаж, 7927 толгой мал хорогдож, холбооны шон 5, нурсан гэр 565, барилгын дээвэр хуурч унасан тохиолдол 17, эвдэрсэн хашаа 63, шороон шуурга, мөндөрт өртсөн авто машины тоо 40 байсан ба 1.0 га тариалангийн талбай болон 69 гэр ой хээрийн түймэрт өртөж улс нийгэмд 4 тэрбум 471 сая 824 мянга 516 төгрөгийн шууд хохирол учирсан.

2026.01.20

Уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн судалгааний хэлтэс
Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн